

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БОЛОН БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛООР ЗАСГИЙН ГАЗАРТ ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГСӨН ШИЙДВЭРИЙН
2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАНИЛЦУУЛГА**

/Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд/

2019.11.20

Улаанбаатар хот

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт “Засгийн газрын гишүүд хагас жил тутам хууль тогтоомж, Улсын Их Хурлаас баталсан бодлогын баримт бичгийн болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, үндсэн чиглэлийн хэрэгжилтийн талаархи тайланг холбогдох Байнгын хороонд ирүүлнэ” гэж заасны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас “Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоол, шийдвэрийн 2019 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайлан”-г 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн ХЭГ/3000 тоот албан бичгээр Улсын Их Хурлын Тамгын газарт ирүүлсэн.

“Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн шийдвэрийн 2019 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн танилцуулга”-ыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тайланд үндэслэн Байнгын хорооны эрхлэх асуудал тус бүрээр гаргасан болно. Мөн бүрэн хэрэгжсэн хууль тогтоомжийг хяналтаас хасах тухай Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн саналыг хавсаргав.

“Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн шийдвэрийн 2019 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн танилцуулга”-ыг Улсын Их Хурлын www.parliament.mn цахим сүлжээнд байршуулсан болно.

**ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ХУУЛИАР ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ЗАСГИЙН
ГАЗРЫН ГИШҮҮДЭД ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГСӨН ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР**

2.1. Монгол Улсын хуулийн хэрэгжилт

Монгол Улсын хуулиар Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд хууль хэрэгжүүлэхтэй нийцүүлэн холбогдох дүрэм, журам, жагсаалтыг батлан гаргах үүрэг өгсөн 101 хуулийн 509 хэсэг, заалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс хяналтанд авч, мэдээллийн санд бүртгэсэн болно.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны эхний хагас жилийн байдлаар 57 хуулийн 206 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлснээс хяналтад байгаа 30 хуулийн 109 хэсэг, заалт буюу 21.4 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 80 хуулийн /давхардсан тоогоор/ 400 хэсэг, заалт буюу 78.6 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна. Харин өмнөх онуудад хяналтаас хасагдсан 41 хуулийн /давхардсан тоогоор/ 97 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээг дахин ирүүлсэн байна.

		Хууль	Хэсэг, заалт
1	2019 оны эхний хагас жилийн байдлаар хяналтанд авсан	101	509
2	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн Үүнээс:	57	206
	- Хяналтанд байгаа	30	109
	- Хяналтаас хасагдсан заалтыг дахин ирүүлсэн	41	97
3	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	80	400

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн 30 хуулийн 109 хэсэг, заалтаас давхардсан тоогоор 16 хуулийн 28 хэсэг, заалт буюу 25.7 хувь нь бүрэн хэрэгжсэн, 24 хуулийн 37 хэсэг, заалт буюу 33.9 хувь нь хэрэгжих шатанд, 19 хуулийн 25 хэсэг, заалт буюу 22.9 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 1 хуулийн 1 хэсэг, заалт буюу 1.0 хувь нь хэрэгжээгүй, 10 хуулийн 18 хэсэг, заалт буюу 16.5 хувь нь хугацаа болоогүй мэдээ ирүүлсэн байна.

2.2.Монгол Улсын хуулиар Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд тусгайлан үүрэг өгсөн заалтын хэрэгжилт

Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн Монгол Улсын 20 хуулийн 81 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналтад авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны эхний хагас жилийн байдлаар 10 хуулийн 36 хэсэг, заалт буюу 44.0 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлснээс 5 хуулийн 12 хэсэг, заалт буюу 33.3 хувь нь бүрэн хэрэгжсэн, 5 хуулийн 8 хэсэг, заалт буюу 22.2 хувь нь хэрэгжих шатанд, 4 хуулийн 6 хэсэг, заалт буюу 16.7 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 5 хуулийн 10 хэсэг, заалт буюу 27.8 хувь нь хугацаа болоогүй буюу үнэлэх боломжгүй байна.

Хуулийн хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	Хууль	Хэсэг, заалт	
	/давхардсан тоогоор/	Тоо	Хувь
Хяналтанд авсан	20	81	100.0
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	10	36	44.4
Үүнээс:			
- бүрэн хэрэгжсэн	5	12	33.3
- хэрэгжих шатанд	5	8	22.2
- хэрэгжилт хангалтгүй	4	6	16.7
- үнэлэх боломжгүй	5	10	27.8
- хэрэгжээгүй	-	-	-

2.3. Мэдээнд гарсан зөрчил

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд байгаа тус байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах дараах 12 хуулийн 45 хэсэг, заалт буюу 56.0 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна. Тухайлбал,

№	Хуулийн нэр	Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй хуулийн хэсэг, заалт
1	Банкны тухай /Шинэчилсэн найруулга 2010.01.28/	54 дүгээр зүйлийн 54.2; 54.3 дахь хэсэг;
2	Жолоочийн даатгалын тухай /2011.10.06/	8.3; 11.2; 15.5; 17.4; 19.8; 20.6; 21.3; 25.3; 26.2; 26.4 дэх хэсэг;
3	Инновацийн тухай /2012.05.22/	17 дугаар зүйлийн 17.1.12 дахь заалт;
4	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай /2015.06.26/	8.1.7 дахь заалт;
5	Монгол Улсын Хөгжлийн банкны тухай /Шинэчилсэн найруулга 2017.02.10/	15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг;
6	Авто замын тухай / Шинэчилсэн найруулга 2017.05.11/	9 дүгээр зүйлийн 9.1.7 дахь заалт;
7	Үндэсний төлбөрийн системийн тухай /2017.05.31/	9.3; 12.3; 13.1; 18.5; 27.3; 33.1; 33.2; 34.1 дэх хэсэг;
8	Концессын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2017.04.14/	9.5; 10.1 дэх хэсэг;
9	Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай /Шинэчилсэн найруулга 2017.12.21/	6.1; 6.2; 6.3; 6.5; 6.6; 9.1; 13.4; 14.2; 14.5; 14.9; 18.2; 19.2; 19.4; 30.4 дэх хэсэг;
10	Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2018.01.12/	27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэг;
11	Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай /2018.06.27/	10.10; 13.5 дахь хэсэг;
12	Багшийн хөгжлийг дэмжих тухай /2018.06.27/	8.3; 9.2 дахь хэсэг.

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

3.1. Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд 2019 оны эхний хагас жилийн байдлаар Улсын Их Хурлаас Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн нийт 80 тогтоолын 268 заалтыг хяналтад авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны эхний хагас жилийн байдлаар 41 тогтоолын 85 заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлснээс хяналтанд байгаа 20 тогтоолын 49 заалт буюу 18.3 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, давхардсан тоогоор 63 тогтоолын 219 заалт буюу 81.7 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Мөн өмнөх онуудад хяналтаас хасагдсан 21 тогтоолын 36 заалтын хэрэгжилтийн мэдээг дахин ирүүлсэн байна.

		Тогтоол	Заалт
1	2019 оны эхний хагас жилийн байдлаар хяналтанд авсан	80	268
2	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн Үүнээс:	41	85
	- Хяналтанд байгаа	20	49
	- Хяналтаас хасагдсан заалтыг дахин ирүүлсэн	21	36
3	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	63	219

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн Улсын Их Хурлын 20 тогтоолын 49 заалтаас давхардсан тоогоор 11 тогтоолын 17 заалт буюу 34.7 хувь нь бүрэн хэрэгжсэн, 7 тогтоолын 19 заалт буюу 38.8 хувь нь хэрэгжих шатанд, 5 тогтоолын 12 заалт буюу 24.5 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 1 тогтоолын 1 заалт буюу 2 хувь нь хэрэгжээгүй байна.

3.2. Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн 20 тогтоолын 54 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналт тавин ажиллаж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны эхний хагас жилийн байдлаар тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний 4 тогтоолын 7 заалт буюу 13.0 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлснээс 3 тогтоолын 4 заалт буюу 57.1 хувь нь бүрэн хэрэгжсэн, 2 тогтоолын 2 заалт буюу 28.6 хувь нь хэрэгжих шатанд, 1 тогтоолын 1 заалт буюу 14.3 хувь нь хэрэгжилт хангалтгүй байна.

Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	УИХ-ын тогтоол /давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
<i>Хяналтанд авсан</i>	20	54	100.0
<i>Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн</i>	4	7	13.0
Үүнээс:			
- <i>Бүрэн хэрэгжсэн</i>	3	4	57.1
- <i>Хэрэгжих шатанд</i>	2	2	28.6
- <i>Хэрэгжилт хангалтгүй</i>	1	1	14.3
- <i>Хэрэгжээгүй</i>	-	-	-
- <i>Үнэлэх боломжгүй</i>	-	-	-

3.3. Мэдээнд гарсан зөрчил

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд байгаа дараах Улсын Их Хурлын 16 тогтоолын 47 заалт буюу 87.0 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна. Тухайлбал,

№	Улсын Их Хурлын тогтоолын нэр	Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй тогтоолын заалт
1	Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай /2012.01.05 №01/	1.1; 1.2; 1.3 дахь заалт;
2	Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай /2012.10.25 №01/	2; 3 дахь заалт;
3	Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай /2014.06.05 №41/	1 дэх заалт;
4	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай /2014.11.13 №69/	2.1; 2.2; 2.5; 3.1; 3.2; 5.1 дахь заалт;
5	Өрийн удирдлагын тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай /2015.02.18 №42/	2 дахь заалт;
6	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндэн чиглэлийг батлах тухай /2015.06.11 №52/	5.3 дахь заалт;
7	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2016 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай /2015.11.13 №93/	3.1; 3.3; 3.4 дэх заалт;
8	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 батлах тухай /2016.02.05 №19/	2.1; 2.2; 2.4 дэх заалт заалт;
9	Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн талаар авах зарим арга хэмжээний тухай /2016.09.07 №40/	2.1; 3.1 дэх заалт;
10	Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай /2016.09.09 №45/	2.1; 2.2 дахь заалт;
11	Монгол Улсын Хөгжлийн банкны талаар авах зарим арга хэмжээний тухай /2016.12.28 №81/	1.1 дэх заалт;
12	“Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай /2017.02.10 №23/	2; 3 дахь заалт;
13	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай /2017.11.16 №70/	3.1; 3.2; 3.3 дахь заалт;
14	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай /2018.05.24 №37/	2; 3.1 дэх заалт;
15	Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай /2018.06.29 №73/	1.1; 1.2; 1.3; 1.4; 1.5; 1.6 дахь заалт;
16	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай /2018.11.15 №84/	1; 2; 3; 4; 5; 6; 7; 8; 9 дэх заалт.

ДӨРӨВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООДЫН ТОГТООЛЫН ТАЛААР

4.1. Байнгын хороодын тогтоолын хэрэгжилт

Улсын Их Хурлын Тамгын газрын Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс 2019 оны эхний хагас жилийн байдлаар Улсын Их Хурлын Байнгын хороодоос Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн нийт 98 тогтоолын 668 заалтыг мэдээллийн санд бүртгэж, хяналтанд авсан.

2019 оны эхний хагас жилийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 33 тогтоолын 138 заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлснээс хяналтанд байгаа 19 тогтоолын 51 заалт буюу 7.6 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, давхардсан тоогоор 91 тогтоолын 617 заалт буюу 92.4 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

		Тогтоол	Заалт
1	2019 оны эхний хагас жилийн байдлаар хяналтанд авсан	98	668
2	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн Үүнээс:	33	138
	- Хяналтанд байгаа	19	51
	- Хяналтаас хасагдсан заалтыг дахин ирүүлсэн	29	87
3	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	91	617

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн 19 тогтоолын 51 заалтаас 5 тогтоолын 7 заалт буюу 13.7 хувь нь бүрэн хэрэгжсэн, 14 тогтоолын 28 заалт буюу 54.9 хувь нь хэрэгжих шатанд, 8 тогтоолын 12 заалт буюу 23.5 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 3 тогтоолын 4 заалт буюу 7.9 хувь нь үнэлэх боломжгүй мэдээ ирүүлсэн байна. Мөн өмнөх онуудад хяналтаас хасагдсан 29 тогтоолын 87 заалтын мэдээг дахин ирүүлсэн байна.

4.2. Эдийн засгийн байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн Эдийн засгийн байнгын хорооны 18 тогтоолын 151 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналт тавин ажиллаж байна.

2019 оны эхний хагас жилийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хяналтанд байгаа тус Байнгын хорооны 3 тогтоолын 3 заалт буюу 2.0 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 17 тогтоолын 148 заалт буюу 98.0 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн 3 тогтоолын 3 заалтаас 2 тогтоолын 2 заалт буюу 67.0 хувь нь хэрэгжих шатанд, 1 тогтоолын 1 заалт буюу 33.0 хувь нь үнэлэх боломжгүй байна.

Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	ЭЗБХ-ны тогтоол /давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
<i>Хяналтанд авсан</i>	18	151	100
<i>Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн</i>	3	3	2.0
Үүнээс:			
- <i>Бүрэн хэрэгжсэн</i>	-	-	-
- <i>Хэрэгжих шатанд</i>	2	2	67.0
- <i>Хэрэгжилт хангалтгүй</i>	-	-	-
- <i>Хэрэгжээгүй</i>	-	-	-
- <i>Үнэлэх боломжгүй</i>	1	1	33.0

4.3. Мэдээнд гарсан зөрчил

Засгийн газрын хэрэг эрхлэх газраас хууль, тогтоомжийн хэрэгжилтийн мэдээг ирүүлэхдээ зарим тохиолдолд батлагдсан огноо, дугааргүй тодорхойгүй мэдээлэл ирүүлж байна. Мөн бүрэн хэрэгжсэн буюу 100 хувь гэж үнэлсэн хэрэгжилтийн мэдээг хянан үзэхэд тодорхой үр дүнд хүрээгүй, хэрэгжих шатандаа байгаа үйл ажиллагааны талаар дурдсан зэрэг зөрчил байна.

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд байгаа 18 тогтоолын 151 заалтаас 17 тогтоолын 148 заалт буюу 98.0 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байгаа нь Байнгын хорооноос гарсан тогтоолын хэрэгжилт хангалтгүй байна гэж үзэхээр байна. Тухайлбал,

№	Эдийн засгийн байнгын хорооны тогтоолын нэр	Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй тогтоолын заалт
1	Монгол Улсын өмнөд бүсийн ашигт малтмалын томоохон орд газруудад шаардагдах дэд бүтцийн хөгжлийн стратегийг тодорхойлох тухай /2009.11.03 №44/	2.1; 2.2; 2.3; 2.4; 2.6; 2.7 дахь заалт;
2	Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн талаар авах зарим арга хэмжээний тухай /2010.06.08 №16/	1.1; 1.2; 1.3; 1.4; 1.5; 1.6; 1.7 дахь заалт;
3	Авто зам, гүүрийн барилга угсралтын ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай /2011.11.23 №23/	1.3; 1.4; 1.5; 1.6; 1.7 дахь заалт;
4	Валютын ханш, газрын тосны бүтээгдэхүүний үнийн тогтвортой байдлыг хангах талаар цаашид авах арга хэмжээний тухай /2012.02.08 №10/	1.1; 1.2; 1.3; 1.4; 1.5; 1.6; 1.7; 1.8; 2.1; 2.2; 2.3; 2.4; 2.5; 3 дахь заалт;
5	“Түлш, эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай /2015.02.05 №02/	1.4 дэх заалт;
6	Шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний талаар /2015.04.08 №10/	1.1/; 1.2/ дахь заалт;
7	Чиглэл өгөх тухай /2016.11.29 №07/	1.1/; 1.2/; 1.3/; 1.4/; 1.5/; 1.6/; 2 дахь заалт;
8	Чиглэл өгөх тухай /2017.06.07 №15/	1.1/; 1.2/; 1.3/; 1.4/; 1.5/; 1.6/; 1.7/; 1.8/; 2 дахь заалт;
9	Чиглэл өгөх тухай /2017.06.07 №16/	1.1/; 1.2/; 1.3/; 1.4/; 1.5/; 1.6/; 1.7/; 2.1/; 2.2/; 2.3/; 2.4/; 2.5/; 2.6/; 3 дахь заалт;

10	Банкны зээлийн хүүг бууруулах зах зээлийн орчныг бүрдүүлэх талаар чиглэл өгөх тухай /2018.04.18 №07/	1.1;/ 1.2;/ 1.3;/ 1.4;/ 1.5;/ 1.6;/ 1.7;/ 1.8;/ 2.1;/ 2.2;/ 2.3;/ 2.4;/ 3.1;/ 3.2;/ 3.3;/ 3.4;/ 3.5;/ 3.6;/ 3.7;/ 4; 5 дахь заалт;
11	Чиглэл өгөх тухай /2018.04.25 №08/	1.1;/ 1.2;/ 1.3;/ 1.4;/ 2.1;/ 2.2;/ 2.3;/ 2.4;/ 2.5;/ 3 дахь заалт;
12	Чиглэл өгөх тухай /2018.05.02 №10/	1.1;/ 1.2;/ 1.3;/ 1.4;/ 1.5;/ 1.6;/ 1.7;/ 1.8;/ 1.9;/ 1.10;/ 1.11;/ 1.12;/ 1.13;/ 2 дахь заалт;
13	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай /АБГББХ, ЭЗБХ 2018.05.09 №05/13/	1.1;/ 1.2;/ 1.3;/ 1.4;/ 1.5;/ 1.6;/ 1.7/ дахь заалт;
14	Чиглэл өгөх тухай /2018.06.05 №17/	1.1;/ 1.2;/ 1.3;/ 1.4;/ 1.5/ дэх заалт;
15	Чиглэл өгөх тухай /2018.10.30 №32/	1.1;/ 1.2;/ 1.3;/ 1.4;/ 1.5;/ 2.1;/ 2.2;/ 2.3;/ 2.4/, 3 дахь заалт;
16	Ипотекийн зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар чиглэл өгөх тухай /2018.11.13 №35/	2.1;/ 2.2;/ 3; 4 дэх заалт;
17	Экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр Засгийн газар, Монголбанканд чиглэл өгөх тухай /2019.04.09 №04/	1.1;/ 1.2;/ 1.3;/ 1.4;/ 1.5;/ 1.6;/ 1.7;/ 2.1;/ 2.2;/ 2.3;/ 2.4;/ 3 дахь заалт.

ТАВ. БҮРЭН БИЕЛСЭН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ХЯНАЛТААС ХАСАХ ТУХАЙ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны эхний хагас жилийн байдлаар Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд бүрэн хэрэгжсэн Монгол Улсын 3 хуулийн 9 хэсэг, заалт, Улсын Их Хурлын 3 тогтоолын 4 заалтыг хяналтаас хасах санал ирүүлснийг хавсралтаар хүргүүлэв.

ЗУРГАА. САНАЛ

1/ Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас тус Байнгын хорооны эрхлэх асуудалд хамаарах хяналтанд байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээг хангалтгүй ирүүлж байна. Тухайлбал тус Байнгын хорооны эрхлэх асуудалд хамаарах хяналтанд байгаа хуулийн 56 хувь, Улсын Их Хурлын тогтоолын 87.7 хувь, Байнгын хорооны тогтоолын 98 хувийн хэрэгжилтийн мэдээг тус тус ирүүлээгүй байна.

2/ Хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээ маш хангалтгүй ирж байгаа бөгөөд 2017, 2018 онд ирүүлсэн хэрэгжилтийн мэдээнд тодорхой өөрчлөлт оруулахгүй 2019 оны хэрэгжилтийн мэдээг ирүүлж байна.

3/ Улсын Их Хурлын Тамгын газраас хагас жил тутам хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд хяналт шинжилгээ хийж, тодорхой санал, зөвлөмжийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлдэг боловч тухайн санал зөвлөмжийг ажил хэрэг болгохгүй байгаа нь хэрэгжилтийн мэдээнээс харагдаж байна.

МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД
БҮРЭН ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛИЙН ЖАГСААЛТ**
/2019 оны эхний хагас жилийн байдлаар/

№	Хуулийн нэр, огноо	Заалтын агуулга	Хэрэгжилт
1	Барилгын тухай /шинэчилсэн найруулга/ 2016.02.05	6.3 Барилгын үйл ажиллагаанд олон улсын байгууллага, гадаадын барилга байгууламжийн норм, дүрэм, стандартыг бүртгэх, хэрэглэх журмыг Засгийн газар батална.	Барилга, хот байгуулалтын яам Засгийн газрын 2019 оны 107 дугаар тогтоолоор “Барилгын үйл ажиллагаанд олон улсын байгууллага, гадаадын барилга байгууламжийн норм, дүрэм, стандартыг бүртгэх, хэрэглэх журам” батлагдсан.
2	Авто замын тухай /Шинэчилсэн найруулга/ 2017.05.11	9.1.8 тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих, ашиглах журам батлах.	Зам, тээврийн хөгжлийн яам Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих, ашиглах журмыг 2018 оны 12 дугаар сард Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж баталсан.
		10.1.7 тусгай зориулалтын авто зам барих, засварлах, ашиглахтай холбоотой журмыг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангах;	Зам, тээврийн хөгжлийн яам Тусгай зориулалтын авто зам барих, засварлах, ашиглах журмыг 2018 оны 12 дугаар сард Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан.
		26.2 Авто замын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Зам, тээврийн хөгжлийн яам Авто замын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 11-ний өдөр 282 дугаар тушаалаар батлуулсан.
		30.2 Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах журмыг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Зам, тээврийн хөгжлийн яам Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах журмыг 2018 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Зам, тээврийн хөгжлийн сайдын 274 дүгээр тушаалаар баталсан.
		31.2 Авто зам, замын байгууламжийг хаах, замын чиглэл өөрчлөх журмыг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Зам, тээврийн хөгжлийн яам Авто зам, замын байгууламжийг хаах, замын чиглэл өөрчлөх журмыг 2018 оны 6 дугаар сард Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар баталсан.
3	Усан замын тээврийн тухай /шинэчилсэн найруулга/ 2017.05.25	5.1.5 усан замын тээврийн хэрэгслийн ангилал, зориулалтыг харгалзан техникийн хяналтын үзлэгийн төлбөрийн жишгийг ялгавартай тогтоох.	Зам, тээврийн хөгжлийн яам Усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн төлбөрийн жишиг тогтоох тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж 2019 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 01/3052 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлэв. Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанд хэлэлцүүлж шийдвэрлүүлэв.

		6.1.12 усан замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектод гэрчилгээ олгох журам, гэрчилгээний загварыг батлах;	Зам, тээврийн хөгжлийн яам Хуульд заасан энэхүү журмыг шинээр боловсруулан Сайдын 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 78 дугаар тушаалаар батлуулсан бөгөөд ХЗДХ-ны дотоодын хяналтын бүртгэлд 4283 тоотгоор бүртгүүлсэн.
		6.1.13 усан замын объект болон усан замын тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дүрмийг батлах;	Зам, тээврийн хөгжлийн яам Хуульд заасан энэхүү журмыг шинээр боловсруулан Сайдын 2018 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 277 дугаар тушаалаар батлуулсан бөгөөд ХЗДХ-ны дотоодын хяналтын бүртгэлд 4080 тоотгоор бүртгүүлсэн.
Нийт 3 хуулийн 9 хэсэг, заалт			

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД БҮРЭН ХЭРЭГЖСЭН,
ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ЖАГСААЛТ**

/2019 оны эхний хагас жилийн байдлаар/

№	Тогтоолын нэр, огноо, дугаар	Заалтын агуулга	Хэрэгжилт
1.	Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2013.01.10 №06	1.2 банкуудыг хадгаламжийн даатгалын үйл ажиллагаанд хамруулах арга хэмжээ авах: 1.3 Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 10.2.2, 10.2.3-т заасан хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд шаардлагатай 100.0 тэрбум төгрөгийн 50.0 тэрбум төгрөгийг Засгийн газраас, 50.0 тэрбум төгрөгийг Монголбанкнаас тус тус гаргаж, мөн хуулийн 19.5-д заасны дагуу Монголбанкинд нээсэн Хадгаламжийн даатгалын корпорацийн дансанд төвлөрүүлэх;	Сангийн яам Хадгаламжийн даатгалын сангийн эхлэлийн хөрөнгө болох төсвөөс төлөгдөх 50.0 тэрбум төгрөгийн 42.2 тэрбум төгрөгийг Хадгаламжийн даатгалын санд байршуулсан. Хадгаламжийн даатгалын сангийн хөрөнгө 2019 оны 5 дугаар сарын байдлаар 421,6 тэрбум төгрөг байгаа бөгөөд энэ нь жижиг 8 банкуудын эрсдэлийг зэрэг даахаар байна. Мөн Банкны салбарын тогтвортой байдлын тухай хууль батлагдсан тул Засгийн газраас ижил хөрөнгө оруулахгүй байх чиглэлийг барьж байна. Сангийн яам Хадгаламжийн даатгалын сангийн эхлэлийн хөрөнгө болох төсвөөс төлөгдөх 50.0 тэрбум төгрөгийн 42.2 тэрбум төгрөгийг Хадгаламжийн даатгалын санд байршуулсан. Хадгаламжийн даатгалын сангийн хөрөнгө 2019 оны 5 дугаар сарын байдлаар 421,6 тэрбум төгрөг байгаа бөгөөд энэ нь жижиг 8 банкуудын эрсдэлийг зэрэг даахаар байна. Мөн Банкны салбарын тогтвортой байдлын тухай хууль батлагдсан тул Засгийн газраас ижил хөрөнгө оруулахгүй байх чиглэлийг барьж байна.
2.	“Эдийн засгийг сэргээх хөтөлбөр” батлах тухай 2016.11.24 №71	2.2 Энэ тогтоолын хавсралтад заасан банк, санхүү, төсөв, бодит салбарын үйл ажиллагааг дэмжих, тогтворжуулахад шаардагдах хөрөнгийг гадаад, дотоод эх үүсвэрээс нэн даруй босгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Сангийн яам Эдийн засгийг сэргээх хөтөлбөр 2018 оны эхний хагас жилд хэрэгжиж дууссан болно.
3.	“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл” батлах тухай 2017.05.31 №42	3. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг баталсантай холбогдуулан хэрэгжилтийг оны эхнээс жигд ханган зохион байгуулж, биелэлтийг бүтэн жилээр гаргаж, Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т даалгасугай.	Сангийн яам Улсын Их Хурлын 2017 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2019-2020 оны төсвийн төсөөллийн тухай хууль, бодлогын бусад баримт бичиг, хөтөлбөртэй уялдуулан хэрэгжилтийг зохион байгуулж ажиллаа. Үндсэн чиглэлийн жилийн эцсийн биелэлтэд Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг 2019 оны 1

			<p>дүгээр сарын 31-ний өдрийн 5-2/512 албан тоотоор Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлж, Улсын Их Хурлын чуулганы 2019 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн нэгдсэн хуралдаанд танилцуулав. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд туссан нийт 136 арга хэмжээнээс давхардсан тоогоор 97 буюу 71.9 хувь нь “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-тай, 124 буюу 91.9 хувь нь Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй, 19 буюу 14.1 хувь нь Эдийн засгийг сэргээх хөтөлбөртэй, 14 буюу 10.4 хувь нь Төрөөс баримтлах бодлоготой, 3 буюу 2.2 хувь нь Үндэсний хөтөлбөртэй тус тус уялдсан бөгөөд нийт 5 бодлого, 18 зорилт, 136 арга хэмжээний биелэлтийг 2018 оны жилийн эцсийн байдлаар холбогдох яам, агентлагуудаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн үнэлэхэд биелэлт 76.7 хувьтай гарлаа.</p>
<p>Нийт 3 тогтоолын 4 заалт</p>			